

**БАЯНХОНГОР АЙМАГ НЭГДСЭН ЭМНЭЛЭГ**

Огноо:2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр

**БАЯНХОНГОР АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГТ  
ЦЭВЭРЛЭГЭЭ, АЖ АХУЙН МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр:** Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн хэрэгцээнд  
цэвэрлэгээ, аж ахуйн материал нийлүүлэх

**Харьцуулалт/  
гэрээний дугаар:** БХАНЭ/2020004

**Баянхонгор аймаг  
2020 он**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**[Аймгийн Нэгдсэн эмнэлэг]** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **[Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн хэрэгцээнд цэвэрлэгээ, аж ахуйн материал]**–ийг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50 000 (Тавин мянга)** төгрөг.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулинд нийцүүлэн тендерийн баримт бичигт тодорхойлсон журам болон Харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгоно.

Энэ урилгад заагдаагүй бусад нөхцлийг тендерийн баримт бичигт тусгасан болно

Тендерийг **2020 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 30 минутанд нээнэ.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх.Тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг Ерөнхий нягтлан бодогч  
Д.Сайнбаяр Утас:88118635**

**Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - Үнийн санал маягтаар ирүүлэх
    - Бараа нийлүүлэх хуваарь ирүүлэх
    - Улсын бүртгэлийн гэрчилгээ / эх хувиас ирүүлэх /
    - Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт / эх хувиас ирүүлэх /
    - Шүүхийн магадлагаа / эх хувиас ирүүлэх/
    - ШШГГ-ын тодорхойлолт ирүүлэх /эх хувь ирүүлэх/
    - Гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг зөвшөөрч байгаа мэдэгдэл.
    - Татвар, харилцагч банкнаас тодорхойлолт ирүүлэх
- 4. Тогтмол үнэ**
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-Д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> <li>➤ Үнийн санал маягтаар ирүүлэх</li> <li>➤ Бараа нийлүүлэх хуваарь ирүүлэх</li> <li>➤ Улсын бүртгэлийн гэрчилгээ / эх хувь /</li> <li>➤ Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт/эх хувь/</li> <li>➤ Шүүхийн магадлагаа / эх хувь/</li> <li>➤ ШШГГ-ын тодорхойлолт ирүүлэх /эх хувь /</li> <li>➤ Гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг зөвшөөрч байгаа мэдэгдэл.</li> <li>➤ Татвар, харилцагч банкнаас тодорхойлолт ирүүлэх /эх хувь/</li> <li>➤ Нийгмийн датгалын хэлтсийн тодорхойлолт /эх хувь/</li> <li>➤ Ижил төстэй ажил хийж гүйцэтгэж байсан туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх.</li>   <li>➤ Сүүлийн [2] жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээ, хүлээлгэн өгсөн акт, захиалагч байгууллагын тодорхойлолтуудыг эх хувиас ирүүлэх/;</li> <li>➤ Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: <b>15 саяаас багагүй байх</b></li> <li>➤ Борлуулалтын хэмжээ: сүүлийн 2 жилийн дундаж: <b>Санал болгож буй үнийн дүнгийн 60%-иас багагүй байх</b></li> <li>➤ Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн<sup>1</sup> нийт дүн: <b>10 сая төгрөгөөс багагүй байх</b></li> <li>➤ Нийлүүлэх барааны танилцуулга, фото зураг, Цэвэрлэгээний бээлий, Шингэн саван “Дэлбээ”, “Сараана” сальфетканд дээж ирүүлэх</li> <li>➤ Тухайн бараа бүтээгдэхүүн нийлүүлэхэд чанарын шаардлага хангахгүй бараа нийлүүлбэл өөрийн зардалаар дахин солиж өгөх албан тоот ирүүлэх.</li> </ul>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:          Байгууллагын хаяг: <b>Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг</b>          Давхар болон өрөөний дугаар: <b>Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг Амбулаторийн 2 давхар Ерөнхий нягтлан бодогч Д.Сайнбаяр</b></p> <p>Огноо: 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:          Байгууллагын хаяг: <b>Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг</b>          Давхар болон өрөөний дугаар: <b>2 давхарт 210 тоот өрөө</b></p>

<sup>1</sup> Авах боломжтой зээл гэдэгт зээлжих баталгаажсан эрх, харилцагч банкнаас зээл олгох албан мэдэгдэл зэрэг байж болно.

	<b>Ерөнхий нягтлан бодогч</b> Огноо: <b>2020 оны 02 дугаар сарын 10-ны өдөр</b> Цаг: <b>10 цаг 30 минутад</b>
<b>ТӨӨЗ 6.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>2 багц</b> 1 багц: Цэвэрлэгээ, аж ахуйн материал 2 багц: Цэвэрлэгээ, аж ахуйн материал /дотоодын үйлдвэрлэл/

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

## БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Баянхонгор Нэгдсэн эмнэлэг

1 дүгээр багц:

Цэвэрлэгээ аж ахуйн материал

№	Барааны нэр, тодорхойлолт	Чанар	Тоо, хэмжээ	<sup>[1]</sup> Нийлүүлэх хуваарь <sup>[2]</sup> хойш /, долоо хоног, сараар/
1	Угаалгын нунтаг	"White" 300 гр эсвэл түүнтэй дүйцэхүйц	2508	Сард-202 /тухайн сарын 25-ны дотор/
2	Угаалгын нунтаг	"Омо" 3 кг эсвэл түүнтэй дүйцэхүйц	168	Сард-16 /тухайн сарын 25-ны дотор/
3	Гарын саван	"Вазелиновое" 90 гр, саван эсвэл түүнтэй дүйцэхүйц /гар хуурайшуулдаггүй, будагч бодис болон элдэв үнэргүй, харшил төрөгчгүй байх/	1644	Сард-144 /тухайн сарын 25-ны дотор/
4	Шингэн саван	500 мл-тэй бактерийн эсрэг байх, // эсвэл түүнтэй дүйцэхүйц /гар хуурайшуулдаггүй, будагч бодис болон элдэв үнэргүй, харшил төрөгчгүй байх/	1368	Сард-111 /тухайн сарын 25-ны дотор/
5	Белизна	"Titiz" 1000 мл-ээр савлагдсан сайн чанарын байх, эсвэл түүнтэй дүйцэхүйц	228	Сард-15 /тухайн сарын 25-ны дотор/

6	Комит	"Titiz" 450 гр-аар савлагдсан орос, сайн чанарын байх эсвэл түүнтэй дүйцэхүйц	324	Сард-29 /тухайн сарын 25-ны дотор/
7	Пери	"Titiz" 500 мл-ээр савлагдсан сайн чанарын байх эсвэл түүнтэй дүйцэхүйц	108	Сард-9 /тухайн сарын 25-ны дотор/
8	00-ийн бээлий	Сайн чанарын байх, тохой хүртлэх урттай, хагас даавуун дотортой, Солонгос улсад үйлдвэрлэсэн эсвэл түүнтэй дүйцэхүйц	1500	Сард-108 /тухайн сарын 25-ны дотор/
9	Цэвэрлэгээний бээлий	Сайн чанарын байх, Солонгос улсад үйлдвэрлэсэн эсвэл түүнтэй дүйцэхүйц	1656	Сард-125 /тухайн сарын 25-ны дотор/
10	Скоч	Радиус нь 8 см хэмжээтэй сайн чанарын байх эсвэл түүнтэй дүйцэхүйц	384	Сард-31 /тухайн сарын 25-ны дотор/
11	ОО-ын утас	Даавуун сайн чанарын эсвэл түүнтэй дүйцэхүйц	36	Сард-3 /тухайн сарын 25-ны дотор/
12	Уут боодол	Таславчтай сайн чанарын байх эсвэл түүнтэй дүйцэхүйц	36	Сард-2 /тухайн сарын 25-ны дотор/
13	Гялгар уут /20x20: 30x20, амыг нь түгжих боломжтой/	Сайн чанарын байх эсвэл түүнтэй дүйцэхүйц	300	1 удаа
14	"А" даавуу	Орос 60 см-ийн өргөнтэй эсвэл түүнтэй дүйцэхүйц	1848	Сард-140 /тухайн сарын 25-ны дотор/
15	Хар уут	Боодолдоо 100 ш-тэй 0.05 мл/мкр зузаантай 65x80 мм Хог, хаягдал хийх зориулалт хар өнгө бүхий сайн чанарын байх эсвэл түүнтэй дүйцэхүйц	36000	Сард-3000 /тухайн сарын 25-ны дотор/

16	Шар уут	Боодолдоо 100 ш-тэй 0.05 мл/мкр зузаантай 65x80 мм Хог, хаягдал хийх зориулалт шар өнгө бүхий сайн чанарын байх эсвэл түүнтэй дүйцэхүйц	39600	Сард-3350 /тухайн сарын 25-ны дотор/
----	---------	---	-------	---

2 дугаар багц: Цэвэрлэгээ аж ахуйн материал /дотоодын үйлдвэрлэл/

№	Барааны нэр, тодорхойлолт	Чанар	Тоо, хэмжээ	<sup>[1]</sup> Нийлүүлэх хуваарь <sup>[2]</sup> хойш /, долоо хоног, сараар/
1	Эдийн саван	"Топ" 300 гр эсвэл түүнтэй дүйцэхүйц	3348	Сард-285 /тухайн сарын 25-ны дотор/
2	Сальфетка	"Дэлбээ" эх орны үйлдвэрийн сайн чанарын байх, эсвэл түүнтэй дүйцэхүйц	156	Сард-14 /тухайн сарын 25-ны дотор/
3	Сальфетка	"Сарана" эх орны үйлдвэрийн сайн чанарын байх, эсвэл түүнтэй дүйцэхүйц	1860	Сард-129 /тухайн сарын 25-ны дотор/

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.



Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:  
 Санал болгож буй бусад нөхцөл:  
 Тендерт оролцогчийн нэр:  
 Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:  
 Албан тушаал, нэр:  
 Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[моо]</b> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |

- 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах**
- 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11. Маргааныг шийдвэрлэх**
- 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
- Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ**
- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
  - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:  
Гэрээний үнийн дүнгийн  $[moo]^2$  хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуула**
- 9.1. Алданги оногдуулах хувь: **[10%]**

<sup>2</sup> Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

х (ГЕН - 9)<sup>3</sup>

Алдангийн нийт дүн: [10%]

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>4</sup>**БАТЛАВ.****ЗАХИАЛАГЧ****НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....  
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

<sup>3</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

<sup>4</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_  
нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>5</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:****НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар] [Харилцагч банкны нэр, дансны дугаар]

<sup>5</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.